

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, САНГИЙН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 1 дугаар  
сарын 29 ны өдөр

Дугаар...

114/16

Улаанбаатар  
хот

Сургалтын төлбөрийн хэмжээ,  
зардлын норматив батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Харуул хамгаалалтын чиглэлийн албаны нохой ашиглах /3 сарын хугацаатай/ сургалтын төлбөрийн хэмжээг 2010000 /хоёр сая арван мянган/ төгрөг, галт зэвсэг эзэмших, ашиглах сургалтын төлбөрийн хэмжээг 150000 /нэг зуун тавин мянга/ төгрөг, гэрээт харуул хамгаалалтын сургалтын төлбөрийн хэмжээг 199260 /нэг зуун ерэн есөн мянга хоёр зуун жар/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.“Харуул хамгаалалтын чиглэлийн албаны нохой ашиглах сургалтын нэг нохойгоор тооцсон зардлын норматив”-ыг нэгдүгээр, “Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын нэг иргэнээр тооцсон зардлын норматив”-ыг хоёрдугаар, “Гэрээт харуул хамгаалалтын сургалтын нэг иргэнээр тооцсон зардлын норматив”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Энэ тушаалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа С.Баатаржав/, цагдаагийн байгууллагын жил бүрийн төсөвт зохих санхүүжилтийг тусгаж байхыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Н.Цэвэлмаа/, Сангийн яамны Төсвийн бодлогын газар /Ж.Ганбат/-д тус тус даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайд, Сангийн сайдын 2016 оны 14/A/10 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Хууль зүй, дотоод хэргийн  
сайд, Сангийн сайдын хамтарсан 2018  
оны 1 дугаар сарын 22-ны өдрийн  
А/14.1.19 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт

**ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ЧИГЛЭЛИЙН АЛБАНЫ  
НОХОЙ АШИГЛАХ СУРГАЛТЫН НЭГ НОХОЙГООР  
ТООЦСОН ЗАРДЛЫН НОРМАТИВ**

Нэг.Харуул хамгаалалтын чиглэлийн албаны нохойн 3 сарын хугацаатай сургалт.

**1.1.Хоолны зардал**

| Д/д            | Материалын нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ  |
|----------------|----------------------|-------------|-------------|----------------|-----------|
| 1              | Хуурай бэлэн хоол    | Кг          | 93          | 12,000         | 1,116,000 |
| 2              | Лакмуст /амтат зүйл/ | хоног       | 90          | 600            | 54,000    |
| Нийт:1,170,000 |                      |             |             |                |           |

Жич: Захиалагч нохойн хоолоо өөрсдөө өгсөн тохиолдолд төлбөрөөс чөлөөлөгдөнө.

**1.2.Тоног хэрэглэл**

| Д/д          | Материалын нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|--------------|----------------------|-------------|-------------|----------------|----------|
| 1            | Урт оосор            | ширхэг      | 1           | 35,000         | 35,000   |
| 2            | Богино оосор         | ширхэг      | 1           | 30,000         | 30,000   |
| 3            | Хүзүүвч              | ширхэг      | 1           | 35,000         | 35,000   |
| 4            | Хошуувч              | ширхэг      | 1           | 35,000         | 35,000   |
| 5            | Чээживч              | ширхэг      | 1           | 40,000         | 40,000   |
| 6            | Өргөст хүзүүвч       | ширхэг      | 1           | 25,000         | 25,000   |
| 7            | Гадас                | ширхэг      | 1           | 15,000         | 15,000   |
| 8            | Даавуун бөмбөг       | ширхэг      | 5           | 3000           | 15,000   |
| 9            | Резинэн бөмбөг       | ширхэг      | 6           | 5000           | 30,000   |
| 10           | Модон апорт          | ширхэг      | 6           | 6000           | 36,000   |
| 11           | Зуултын ханцуйвч     | ширхэг      | 1           | 55,000         | 55,000   |
| Нийт:351,000 |                      |             |             |                |          |

Жич:Захиалагч нохойн тоног хэрэглэлээ өөрсдөө өгсөн тохиолдолд энэ тооцооны 1.2-д заасан төлбөрөөс чөлөөлөгдөнө.

### 1.3.Сургалттай холбоотой бусад зардал

| Д/д          | Материалын нэр төрөл                                       | Хэмжих нэгж | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|--------------|------------------------------------------------------------|-------------|-------------|----------------|----------|
| 1            | Сургалтын материал, шаардагдах бичиг хэргийн зардал        | ширхэг      | 1           | 10,000         | 10,000   |
| 2            | Сургалтад ашиглах 7,62х39 мм-ийн АК-47 бууны сургалтын сум | ширхэг      | 50          | 1,200          | 60,000   |
| 3            | Багшийн хөлс                                               | цаг         | 22          | 8,000          | 176,000  |
| 4            | Гэрчилгээ, батламж хэвлүүлэх зардал                        | ширхэг      | 1           | 8,000          | 8,000    |
| 5            | Гэрчилгээний хавтас                                        | ширхэг      | 1           | 12,000         | 12,000   |
| 6            | Тээвэр, шатахуун                                           |             |             |                | 40,000   |
| Нийт:306,000 |                                                            |             |             |                |          |

### 1.4.Эм тариа

| Д/д         | Материалын нэр төрөл                               | Хэмжих нэгж | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|-------------|----------------------------------------------------|-------------|-------------|----------------|----------|
| 1           | Таван цэнэгт вакцин                                | тун         | 1           | 20,000         | 20,000   |
| 2           | Туулга                                             | ширхэг      | 1           | 8000           | 8000     |
| 3           | Халдварт галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин | тун         | 1           | 5000           | 5000     |
| 4           | Ариутгалын бодис                                   | литр        | 1           | 15,000         | 15,000   |
| Нийт:48,000 |                                                    |             |             |                |          |

### 1.5.Хөдөлмөр хамгаалалтын хувцас

| Д/д                                               | Материалын нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---------------------------------------------------|----------------------|-------------|-------------|----------------|----------|
| 1                                                 | Сургалтын хувцас     | ширхэг      | 1           | 110,000        | 110,000  |
| 2                                                 | Сургалтын цүнх       | ширхэг      | 1           | 25,000         | 25,000   |
| Нийт:135,000                                      |                      |             |             |                |          |
| Сургалтад зарцуулагдах зардал нийт дүн: 2,010,000 |                      |             |             |                |          |

Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
Сангийн сайдын хамтарсан 2018  
оны...1 дугаар сарын...-ны өдрийн  
А/14...19 дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт

ИРГЭНИЙ БОЛОН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ  
ГАЛТ ЗЭВСЭГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ, АЮУЛГҮЙ  
АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТЫН НЭГ ИРГЭНЭЭР ТООЦСОН  
ЗАРДЛЫН НОРМАТИВ

| № | Зардлын нэр                                                 |               | Тоо<br>хэмжээ | Санал                |             |
|---|-------------------------------------------------------------|---------------|---------------|----------------------|-------------|
|   |                                                             |               |               | Нэг<br>бүрийн<br>үнэ | Нийт<br>үнэ |
| 1 | Сургалтын материал, шаардагдах бичиг хэргийн зардал         |               | 1             | 5,000                | 5,000       |
| 2 | Аюулгүй ажиллагааны гарын авлага                            |               | 1             | 4,500                | 4,500       |
| 3 | Сургалтад ашиглах сум                                       | 5.6 мм        | 3             | 2,500                | 7,500       |
|   |                                                             | 7.62*39 мм    | 4             | 3,500                | 14,000      |
|   |                                                             | 7.62*54 мм    | 4             | 4,500                | 18,000      |
|   |                                                             | 7.62*51 мм    | 3             | 8,000                | 24,000      |
|   |                                                             | 223 remongton | 4             | 6,000                | 24,000      |
| 4 | Буудлагын бай, самбар, бууны тослох, цэвэрлэх материал      |               | 1             | 7,000                | 7,000       |
| 5 | Сургалтад ашиглах анхан шатны эмнэлгийн тусламжийн материал |               | 1             | 5,000                | 5,000       |
| 6 | Тээвэр, шатахуун                                            |               | 1             | 7,000                | 7,000       |
| 7 | Гэрчилгээ хэвлүүлэх зардал                                  |               | 1             | 5,000                | 5,000       |
|   | Гэрчилгээний хавтас                                         |               | 1             | 5,000                | 5,000       |
| 8 | Буудлага, дадлагад оролцогчдын өдрийн хоол                  |               | 2             | 8,000                | 16,000      |
| 9 | Сургагч багшийн урамшуулал                                  |               | 16 цаг        | 8,000                | 8,000       |
|   | Нийт зардал                                                 |               |               |                      | 150,000     |

Хууль зүй, дотоод хэргийн сайд,  
Сангийн сайдын хамтарсан 2018  
оны...1 дугаар сарын...-ны өдрийн  
11/14/19 дугаар тушаалын гуравдугаар  
хавсралт

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН СУРГАЛТЫН НЭГ  
ИРГЭНЭЭР ТООЦСОН ЗАРДЛЫН НОРМАТИВ

| № | Зардлын нэр                                                 |         | Тоо<br>хэмжээ | Санал                |             |
|---|-------------------------------------------------------------|---------|---------------|----------------------|-------------|
|   |                                                             |         |               | Нэг<br>бүрийн<br>үнэ | Нийт<br>үнэ |
| 1 | Сургалтын материал, шаардагдах бичиг хэргийн зардал         |         | 1             | 5,000                | 5,000       |
| 2 | Аюулгүй ажиллагааны гарын авлага                            |         | 2             | 4,500                | 9,000       |
| 3 | Сургалтад ашиглах сум                                       | 9мм     | 5             | 2,500                | 12,500      |
|   |                                                             | 7.62 мм | 5             | 3,500                | 17,500      |
| 4 | Буудлагын бай, самбар, бууны тослох, цэвэрлэх материал      |         | 1             | 5,000                | 5,000       |
| 5 | Сургалтад ашиглах анхан шатны эмнэлгийн тусламжийн материал |         | 1             | 9,000                | 9,000       |
| 6 | Тээвэр, шатахуун                                            |         | 1             | 10,260               | 10,260      |
| 7 | Гэрчилгээ хэвлүүлэх зардал                                  |         | 1             | 5,000                | 5,000       |
|   | Гэрчилгээний хавтас                                         |         | 1             | 5,000                | 5,000       |
| 8 | Буудлага, дадлагад оролцогчдын өдрийн хоол                  |         | 2             | 8,000                | 16,000      |
| 9 | Сургагч багшийн урамшуулал /15 сургагч багшид олгоно/       |         | 15<br>хоног   | 7,000                | 105,000     |
|   | Нийт зардал                                                 |         |               |                      | 199,260     |

----o0o----